

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗААВАР

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Эрсдэлийн удирдлагын заавар (“Заавар”)–ыг Компани болон түүний охин компаниудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянахад баримталж ажиллана.

1.2. Хамрах хүрээ

Компани болон түүний охин компаниудын эрх бүхий албан тушаалтан, ажилтан энэхүү Зааврыг дагаж мөрдөнө.

1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“БОНЗ–ын хороо”) тухай бүр, шаардлагатай хэмээн үзсэн үедээ энэхүү Заавар болон түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ–д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

1.4. Зааврын нөхцөл

Энэхүү Заавар болон Компанийн Дүрмийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд Компанийн Дүрэм давуу хүчинтэй байх ба энэ Заавар нь Монгол Улсын хууль, тогтоомжтой нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зохицуулалт нь давуу хүчинтэй байна. Энэхүү Зааврын заалтыг хэрхэн тайлбарлах болон тэдгээрийг хэрэглэхтэй холбогдсон зарим тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн үед бусад ТУЗ–ийн гишүүдийн оролцоотойгоор ТУЗ–ийн даргын саналаар шийдвэрлэнэ. Энэ Зааварт тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн Дүрэм болон бусад эрх зүйн актад зааснаар шийдвэрлэнэ.

2. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. ТУЗ нь Компанийн үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, нэгдсэн үйл ажиллагааг хариуцан, дотооддоо мөрдөх зааврыг Компанийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.

2.2. БОНЗ–ын хороо нь Компанийн эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

2.3. Заавраар Компанийн зорилго, зорилтод нөлөөлөх эрсдэл, ирээдүйд тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу өгөх арга хэмжээ, түүнийг үнэлэх үйл явцад мониторинг хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.

2.4. Гүйцэтгэх захирал нь Эрсдэлийн удирдлагын зааврын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, Компанийн эрсдэлийг тодорхойлон үнэлж, удирдах үйл ажиллагааг явуулна.

2.5. Гүйцэтгэх захирлын дэргэд Компанийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын нэгж, эсхүл ажилтан байх бөгөөд Компанийн бусад удирдлагуудтай байнгын харилцан холбоотой ажиллана.

2.6. Гүйцэтгэх захирал эрсдэлийн удирдлагын нэгж эсхүл ажилтнаар дамжуулан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө Компанид нийцсэн үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

3. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Эрсдэлийг тодорхойлох

Компанид тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс үүсэх магадлалтай эрсдэлийг Компанийн бүхий л түвшинд тодорхойлно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

- 3.1.1. эрсдэлийн шинж чанар (nature of the risk) - хаана, хэзээ, ямар үйл явдал;
- 3.1.2. эрсдэлийн эх үүсвэр (source of the risk) - ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа;
- 3.1.3. эрсдэлийн шалтгаан (cause of the risk) - шууд болон шууд бус шалтгаан;
- 3.1.4. эрсдэлийн нөлөө (effect of the risk) - үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө.

3.2. Эрсдэлийг үнэлэх

Эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлсийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын төвшнөөр нь ангилж, үнэлэх ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.

3.3. Эрсдэлийг удирдах

Эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.